



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/62

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.4.1.5, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж “Өв-Агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-д хаврын тариалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 159,511,000 (нэг зуун тавин есөн сая таван зуун арван нэгэн мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Дээрх санхүүжилтийг өөрийн тариалж, хураан авсан малын тэжээлээр буцаан төлж, аймгийн өвс, тэжээлийн агуулахад 15951 боодол ногоон тэжээлийг төвлөрүүлэхийг “Өв-Агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Р.Намгилрагчаа)-д даалгасугай.

4.Дээрх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0133

Аймгийн Засаг даргын 2024 оны 16 дүгээр
сарын 16-ны өдрийн 7/16 дугаар
захирамжийг хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРЬ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Газар хавах шатахууны зардал	литр	5610	4060	22,776,600
2	Үрлэгээ хийх шатахууны зардал	литр	3740	130000	15,184,400
3	Овьёос, арвай буудайн холимог үр	кг	93500	1300	121,550,000
	Нийт дүн				159,511,000

-оОо-